

ТӨРИЙН АРХИВУУДЫН 2019 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2020 оны 04 дүгээр сарын 06

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийх нийтлэг журам”, Архивын ерөнхий газрын даргын 2017 оны А/144 дүгээр тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ыг тус тус үндэслэн аймаг, нийслэл, салбар, төрөлжсөн архив /цаашид төрийн архив гэнэ/-ын 2019 оны үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ хийлээ.

Хяналт-шинжилгээ, үнэлгээ нь төрийн архивын стратеги зорилт, үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлт, үр дүнг шинжлэн дүгнэх, 2019 онд хэрэгжүүлсэн ажлын тайлан, статистик мэдээг нэгтгэх, цаашид анхаарах асуудлын талаар зөвлөмж өгөхөд чиглэгдлээ.

Хяналт-шинжилгээг хийхдээ төрийн архивын бичвэр тайланг тухайн архивын ерөнхий мэдээлэл, үйл ажиллагааны төлөвлөлтийн талаарх мэдээ, үндсэн үйл ажиллагааны 9 үзүүлэлт бүхий статистик мэдээний хамт гаргуулан авч “Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын хавсралтад заасан чиглэлүүдээр ангилан тайлагнаж байна.

Хяналт-шинжилгээ үнэлгээг хийхдээ үндсэн 3 зорилтын хүрээнд архивын үйл ажиллагааг ангилж авч үзлээ. Үүнд:

Нэг. Төлөвлөлт, удирдлага, зохион байгуулалтын талаар

1.1. Төрийн архивын үйл ажиллагааны төлөвлөлтийн талаар:

Төрийн архивууд нь 2019 оны үйл ажиллагаандаа Архивын тухай хууль, Засгийн газрын болон аймаг, нийслэлийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймаг, нийслэлийн Засаг дарга нартай тухайн онд байгуулсан Хамтран ажиллах гэрээ, архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Төрийн архивын ажлын үндсэн заавар болон холбогдох заавар, журмуудтай уялдуулан ажлаа төлөвлөж хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус архивууд нь 2019 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг харьяалах дээд байгууллагын удирдлагаар батлуулан хэрэгжүүлж, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл нь 95-100 хувийн биелэлттэй гэж ирүүлсэн нь төлөвлөлт, гүйцэтгэл хангалттай байгааг харуулж байна. Дээр дурдсан хууль тогтоомж, бодлогын баримт бичиг, гэрээтэй уялдуулан төрийн архивууд 2019 оны үйл ажиллагаандаа 5-197 ажил /арга хэмжээ/ төлөвлөсөн бөгөөд нийт 1353 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллажээ. Төрийн архивууд нь 2019 онд Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтөд улсын үзлэг /цаашид “Улсын үзлэг” гэх/-т бэлтгэх ажлын хүрээнд бүтцийн нэгж, албан хаагчид, салбар, орон нутгийн харьяа байгууллагуудын ажилтнуудад сургалт, заавар зөвлөгөө өгөх, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, ном гарын авлагаар хангах,

урьдчилсан үзлэг шалгалт явуулах чиглэлд анхаарч холбогдох шийдвэрүүдийг эрх бүхий албан тушаалтнаар батлуулан ажилласан байна.

Архивуудын төлөвлөгөөний биелэлт 96,0 хувьтай байгаа нь өмнө оны үзүүлэлтээс 0,3 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Үйл ажиллагааны төлөвлөгөөний биелэлтийг хүснэгтээр харуулбал:

Д/д	Архивын нэр	2018 он			2019 он		
		Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь	Төлөвлөсөн арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь
1	Нийт 36	1405	1382	95,7	1353	1319	96,0
2	2019 онд өссөн +/-, буурсан +/- дүн/Төлөвлөсөн арга хэмжээний тоо/				-52		+0,3

Гэвч ирүүлсэн тайлангаас харахад төрийн архивуудын өмнөх онуудын үйл ажиллагаанд хийсэн тайланд дурдсан тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгжээрээ дүгнүүлж ирүүлээгүй байна. Энэ нь Төрийн албаны тухай хуулийн шинэчлэн найруулга 2019 оны 01 сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн, тус хуулийг дагалдан гарсан дүрэм, журмуудын хүрээнд төрийн албан хаагч, нэгжийн төлөвлөлт, тайлагналттай холбоотой дүрэм журам, загвар шинэчлэн батлагдсантай холбоотой гэж үзлээ.

Мөн Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлт, Монгол Улсын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт, Хууль зүй, дотоод хэргийн сайдаас аймаг, нийслэл, агентлагийн дарга нартай байгуулсан гэрээний биелэлтийг ирүүлсэн боловч журамд заасан хугацаа хоцроож ирүүлэх, ирүүлэхгүй тохиолдол байгаад анхаарах шаардлагатай байна.

Хоёр. Төрийн архивын үндсэн үйл ажиллагааны талаар

2.1. Мэргэжил арга зүй, сургалтын талаар

Тайлант хугацаанд төрийн архивууд хөмрөг үүсгэгч байгууллага /нэгжүүд/-д 3767 удаа арга зүйн зөвлөгөө өгч, 1801 удаа сургалт зохион байгуулсан байна. 2019 онд улсын хэмжээнд “Улсын үзлэг” явагдсантай холбогдуулан хөмрөг үүсгэгч байгууллага, зохион байгуулалтын нэгж ажилтнуудад арга зүйн зөвлөгөө, сургалт зохион байгуулах талаар ихээхэн анхаарал хандуулж ажиллажээ. Тухайлбал: Хөмрөг үүсгэгч байгууллагад зохион байгуулсан сургалтын тоогоор Хэнтий, Дундговь, Орхон, аймгийн архивууд, нийслэл, салбар, төрөлжсөн архивуудаас /цаашид “салбар төрөлжсөн архив” гэх/ Нийслэлийн архивын газар, Батлан хамгаалахын төв архив, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв архив зэрэг тэргүүлж байна.

Мөн ажилтныг мэргэшүүлэх давтан сургах талаар төрийн нийт архивууд анхаарч ажилласан бөгөөд аймгуудаас Өвөрхангай, Архангай, Төв, Сүхбаатар аймгийн архивууд, салбар төрөлжсөн архивуудаас Батлан хамгаалахын төв архив, Хил хамгаалахын төв архив, Эрүүгийн хэргийн төв архивууд нь олон ажилтныг хамруулсан үзүүлэлттэй байна.

2.2. Архивын сан хөмрөгийн нөхөн бүрдүүлэлт, нягтлан шалгалт

Төрийн архивууд нь Төрийн архивын ажлын үндсэн заавар /цаашид ТААҮЗ” гэх/-ын 3.1.4-т заасны дагуу “Архивын сан хөмрөгийг нөхөн бүрдүүлэх үндсэн болон боломжит эх үүсвэрийн жагсаалт”-ын дагуу боловсруулсан нөхөн бүрдүүлэх төлөвлөгөө, хуваарийн дагуу сан хөмрөгөө баяжуулжээ.


Тус онд төрийн архивууд нь баримтын онцлог, хөмрөг үүсгэгчийн тоо, архивын хадгаламжийн сангийн багтаамж зэргээс хамаарч 4-860 байгууллага /хөмрөг үүсгэгч/-ын баримтаар сан хөмрөгөө нөхөн бүрдүүлсэн байна. Мөн зарим архивууд нь баримтаа цаасан болон цахим хэлбэрээр авч хэвшсэн нь сайшаалтай байна. Тухайлбал: Баянхонгор, Завхан, Хөвсгөл аймгийн архив, Геологийн баримтын төв архив, Тагнуулын ерөнхий газрын Тусгай архив, Цагдаагийн ерөнхий газрын төв архивууд нь энэ үзүүлэлтээр тэргүүлж байна.

Нөхөн бүрдүүлэлтийн эх үүсвэрээр нь авч үзвэл төрийн 997, төрийн бус 1111, 61 иргэний баримтыг хүлээн авсан байна.



Дээрх тоон мэдээллээс харахад төрийн архивын сан хөмрөгт нөхөн бүрдүүлэлт хийж буй байгууллага /хөмрөг үүсгэгч/-ын тоо жил бүр нэмэгдэж байгаа нь харагдаж байна.

Тус онд төрийн архивууд сан хөмрөгөө нийт 446427 баримтаар нөхөн бүрдүүлснээс удирдлагын 98775 хн, зураг төслийн 12763, гэрэл зургийн 11831, тусгай төрлийн 5210, бусад 301275 хадгаламжийн нэгжээр тус тус сан хөмрөгөө нөхөн баяжуулжээ.



Төрийн архивуудын нөхөн бүрдүүлэлтээр хүлээн авсан баримтын тоо хэмжээ нь бичвэр тайлан, болон тоон мэдээнд тусгасан тоонууд нь зөрүүтэй байдал ихэнх

архивуудад давтагдаж байна. Иймд тайлан тоон мэдээг сайтар хянаж ирүүлж байх талаар анхаарах шаардлагатай байна.

2.3. Архивын баримтын нягтлан шалгалт, дахин боловсруулалтын талаар

Нийт төрийн архивууд 1001 хөмрөг, 1179 данс, 219802 хадгаламжийн нэгжид иж бүрэн нягтлан шалгалт хийсэн байна.

Ирүүлсэн тоон мэдээллээс харахад энэ ажлын үзүүлэлт өмнөх оныхоос буурсан харагдаж байна. Харин Төрийн архивын дэргэдэх Баримт бичиг нягтлан шалгах арга зүйн комиссуудын хуралдсан болон хэлэлцсэн асуудлын тоо өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд хурлаар баримт бичиг хадгалах хугацааны жагсаалт, байнга, түр хадгалах баримтын данс бүртгэл, устгах бичгийн жагсаалт, хосгүй үнэт баримтын жагсаалт зэргийг хэлэлцэх, батлах зэрэг асуудлаар 161 удаа хуралдаж, 3578 асуудлыг хэлэлцсэн нь “Улсын үзлэг” явагдахтай холбогдуулан хөмрөг үүсгэгч байгууллагын баримтын данс, бүртгэл болон бусад шаардлагатай асуудлыг хэлэлцэх ажлыг эрчимжүүлсэнтэй холбоотой гэж үзэж байна.



Цаашид төрийн архивууд нь комиссын хурлаар хэлэлцэх асуудлыг нэг бүрчлэн сайтар хэлэлцэж, хурлын тэмдэглэлээ Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн зааврын 2.4.3-т заасан шаардлагын дагуу хөтөлж, албажуулж байх нь зүйтэй.

2.4. Архивын баримтын тоо бүртгэл, тооллого, эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлт

Төрийн архивуудын үйл ажиллагааны өмнөх жилийн /2018 он/ тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж дүгнэхдээ энэ үзүүлэлтийг голчлон авч үзсэн бөгөөд анхаарах асуудлын талаар тодорхой чиглэл өгсөн болно.

Архивууд нь эрдэм шинжилгээ, мэдээлэл лавлагааны сан бүрдүүлэлтийн ажлыг Архивын тухай хууль болон ТААҮЗ-ын 6.1-д заасан шалгуурын дагуу хийж гүйцэтгэжээ. Эдгээрээс баримтын данс 1199, танилцуулга 315, тойм 167, заагч 728552 үйлдсэн байна.



2.5. Архивын баримтын хадгалалт хамгаалалт

Архивын тухай хуулийн холбогдох заалтууд, ТААҮЗ-ын 5.1-д заасны дагуу архивын зориулалтын байр бариулсан, хадгаламжийн санг нэмэгдүүлсэн, тоног төхөөрөмжөөр хангах, дулаан чийглэгийн хэмжээг тохируулах талаар арга хэмжээ авч ажилласан, ариун цэвэр эрүүл ахуй, баримтыг тоос шороо, хөгц мөөгөнцөр, бичил биет болон гал усны аюулаас сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажилласан байна.

Архивын байр, хадгаламжийн сан, ажилтнуудын өрөө, баримтын хадгалалт хамгаалалтын аюулгүй байдлыг сайжруулах талаар дараах арга хэмжээг авч ажиллажээ. Тухайлбал: Баянхонгор аймаг төрийн архивын байр, сургалтын төв байгуулж, тоног төхөөрөмжөөр хангасан, Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Булган, Говьсүмбэр, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгийн Архивын тасаг, Гадаад харилцааны төв архив, Геологийн баримтын төв архив, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газрын архив мэдээллийн төв, Төмөр замын төрөлжсөн архив, Тагнуулын ерөнхий газрын тусгай архив, Хил хамгаалах ерөнхий газрын төв архив, Цагдаагийн ерөнхий газрын төв архив, Улсын бүртгэлийн ерөнхий газрын төв архив, Цаг уур, орчны шинжилгээний газрын архив, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын төв архив, Эрүүгийн хэргийн төв архив, Эрдэнэт үйлдвэрийн төв архив, Нийслэлийн архив газар зэрэг нь хадгаламжийн сангийн өрөө, ажилтнуудын өрөө, уншлагын танхим, коридорыг иж бүрэн камержуулах, утаа мэдрэгч, хөдөлгөөн илрүүлэгч дохиоллын систем суурилуулсан зэрэг болон баримт хадгалалтын горимд анхаарч хадгаламжийн сангийн чийг, дулааныг тогтмол хэмжиж тэмдэглэх, хадгаламжийн сан баримтын тоос шороог цэвэрлэх, ариутгал хийх зэрэг арга хэмжээг авч ажилласан байна.

Мөн архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхэд шаардлагатай техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авч үйл ажиллагаандаа ашигласан болон вирусын эсрэг программ суулгаж цахим мэдээллийн аюулгүй байдалд анхаарчээ.

Аймгуудын Засаг дарга нараас сумдын Засаг дарга /газар, хэлтсийн дарга/ нартай байгуулсан гэрээнд төрийн архивт хөмрөг үүсгэгч байгууллагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах талаар тодорхой заалт тусгаж хэрэгжүүлэн ажиллажээ.

Эдгээрээс гадна баримтын шинж чанарт шинж чанарт үзлэг хийх, сэлбэн засах, сэргээн шинэтгэх, баримтыг хавтаслах, дугтуй, хамгаалалтын хайрцагт хийх зэрэг

хадгалалт хамгаалалтад анхаарахаас гадна баримтын хадгалалтын болон ашиглалтын хувь үйлдэх зэрэг ажлуудыг гүйцэтгэсэн байна.

Төрийн зарим архивууд баримтын хадгалалт хамгаалалтын талаар бодлогын баримт бичиг батлуулан ажилласан нь сайшаалтай байна. Тухайлбал: Баянхонгор аймгийн архив “Төрийн болон байгууллагын архив, баримтын хадгалалт хамгаалалт, аюулгүй байдал”-ыг хангах дэд хөтөлбөр”, Өвөрхангай аймгийн архив “Цахим архив дэд хөтөлбөр” тус тус батлуулан ажиллажээ.


Мөн архивууд нь сэлбэн засах, сэргээн шинэтгэх баримтыг нягтлан шалгалт, дахин боловсруулалт, баримтын тооллогын явцад илрүүлж, сэлбэн засах, хавтаслах, хайрцаглах зэргээр хадгалалтын нөхцөлд анхаарсан байна.

Тайлант хугацаанд төрийн архивууд нь удирдлагын 103474, зураг төслийн 6409, гэрэл зургийн 11911, тусгай төрлийн 17857 баримтад үзлэг хийж, 54255 баримтыг сэлбэн зассан байна.



2.7. Мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэлт, цахим хувь үйлдсэн байдал


Төрийн архивууд нь “Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлыг амжилттай гүйцэтгэж, сар бүр тайлан мэдээг АЕГ-т ирүүлжээ. Баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхдээ утга, агуулга, үг үсгийн алдаагүй байх, цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хадгалалт хамгаалалтад анхаарах шаардлагатай. Мөн цахим хэлбэрт шилжүүлсэн болон цаашид шилжүүлэх шаардлагатай баримтын тоог тодорхой гаргах нь зүйтэй байна.



2.8. Архивын баримтын ашиглалт, мэдээлэл лавлагаа

Төрийн архивууд нь Архивын тухай хууль, Төрийн архивын ажлын үндсэн заавар, Төрийн архивын баримт ашиглалтын нийтлэг журмын дагуу архивын баримтаас лавлагаа, хуулбар олгох, уншлагын танхимаар баримт олгож судлуулах, баримтыг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, баримтын үзэсгэлэн зохион байгуулах зэргээр баримтын ашиглалт, үйлчилгээг иргэд, байгууллагад үзүүлсэн байна.

Тайлангийн хугацаанд төрийн архивууд нь 247281 иргэд, байгууллагад үйлчилгээ үзүүлж 465936 лавлагаа, хуулбар олгож үйлчилжээ. Энэ үзүүлэлтийг өмнөх оны үзүүлэлттэй харьцуулахад үйлчилгээ авах хүсэлт гаргасан иргэд байгууллагын тоо буурсан боловч олгож буй лавлагаа, хуулбарын тоо өссөн байна.



Гурав. Дүгнэлт

Төрийн архивуудын 2019 оны үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүнгээс харахад төлөвлөгөөний биелэлт нийт төрийн архивын хэмжээнд дунджаар 96,0 хувьтай, энэ нь өмнөх оны 0,3 хувиар өссөн үзүүлэлттэй гарсан бөгөөд “Хангалттай” сайн гэж дүгнэж байна.

Энэ удаагийн хяналт-шинжилгээ, үнэлгээг төрийн архивуудын төлөвлөлт, тайлагналт, баримтын хадгалалт хамгаалалтын чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар голчлон авч үзэж дүгнэсэн болно.

Баримтын хадгалалт хамгаалалтын чиглэлээр төрийн нийт архивууд тодорхой арга хэмжээ авч ажилласан нь сайшаалтай байгааг дурдаж байна.

Төрийн архивуудаас нягтруулсан шүүгээ, зориулалтын тоног төхөөрөмжөөр хангах, байгууллагуудыг архив, бичиг хэрэг хариуцсан орон тоотой болгох, цахимжуулалт хариуцсан ажилтны тоог нэмэгдүүлэх, сэлгэн ажиллуулах, хөдөлмөрийн нөхцөлийг тодорхойлуулах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх зэрэг саналуудыг ирүүлсэн байна.

Төрийн архивын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журмын 6.3-т заасны дагуу үйл ажиллагааны түвшинг үнэлж, жагсааж үзэхэд аймгийн архивууд болон салбар, төрөлжсөн, төв архивуудаас эхний байрт дараах архивууд шалгарлаа. Үүнд:

Нэг. Салбар, төрөлжсөн, төв архивуудаас:

1. “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын төрөлжсөн архив,
2. Нийслэлийн архивын газар,
3. Цагдаагийн ерөнхий газрын төв архив

Хоёр. Аймгийн архивуудаас:

1. Баянхонгор аймгийн архивын тасаг,
2. Архангай аймгийн архивын тасаг,
3. Говьсүмбэр аймгийн архивын тасаг тус тус эхний байруудад шалгарлаа.

Дөрөв. Зөвлөмж

1. Тухайн архивын төлөвлөгөөний биелэлтийг гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлж /үнэлгээний хуудсыг/ 12 дугаар сарын 20-ны дотор ирүүлж байх;

2. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хугацаа дуусч байгаа тул дээрх хугацааны /4 жилийн/ хэрэгжилтийн байдлыг /Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 5.4.11.1, 5.4.11.2, 5.4.11.3/ 2020 оны 05 сарын 15-ны дотор ирүүлэх;

3. Тайлангаа журамд заасан хугацаанд найруулга, үг үсгийн алдаагүй, тоо баримтын зөрүүгүй ирүүлж байх талаар нийт архивын удирдлагууд онцгойлон анхаарах;

4.Төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх 4 дүгээр үе шат 2020 онд дуусч байгаагаар холбогдуулан уг хөтөлбөрийн биелэлтийг /үе шат бүрээр болон 2006-2020 оны хэрэгжилтийн байдлаар/ тус тус хэрэгжилтийн байдлыг дээрх хугацааны дотор ирүүлэх;

5. АЕГ-аас боловсруулан санал авч буй арга зүйн баримт бичгүүдэд тусгах саналаа тухай бүр нь албан бичгээр ирүүлж байх;

6. Тайлан, тоон мэдээг сайтар тулгасны үндсэн дээр ирүүлж байх;

7. Баримтын хадгалалт хамгаалалтын чиглэлээр тодорхой арга хэмжээ авч ажиллах /архивын байр, хадгаламжийн сангийн нөхцөлийг сайжруулах, нягтруулсан шүүгээ, тоног төхөөрөмжөөр хангах/, цахим хэлбэрт шилжүүлсэн баримтын хадгалалтад анхаарах;

8. 2011, 2012 онд АЕГ-аас аймгийн архивуудад өгсөн сервер, компьютерийн хүчин чадал хүрэлцэхгүй болж, ашиглалтын хугацаа дууссантай холбоотойгоор мэдээллийн технологийн техник хэрэгслийн шинэчлэл хийх;

9. Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, программд баримтын талаар шивж оруулах явцад өдөр тутмын хяналтыг тавих зэрэг болно.

АРХИВЫН ЕРӨНХИЙ ГАЗАР